

Сэлэнгэ аймгийн 2013 оны дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд

Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Шаамар суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц баригдаж ашиглалтанд орсон.

Хувийн хөрөнгөөр Аймгийн төв Сүхбаатар суманд иргэн Ц.Болдын үйлчилгээтэй 112



ойлын орон сууц,

Мандал суманд 96 айлын Жаргалан орон сууц, Үйлчилгээтэй 100 айлын орон сууц Тост өргөө хотхон, Сайхан сумын 40 айлын орон сууц тус ашиглалтанд орсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сүхбаатар суманд тээврийн хэрэгслийн оношлогооны төв, Халдвартын 20 ортой эмнэлгийн барилга, Газар хөдлөлтийг бүртгэх станцын барилга, Жавхланта сумын 75 хүүхэдтэй цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтанд орсон.



сангийн хөрөнгө оруулалтаар Жавахлант сумын ахмадын өргөө 30 сая төгрөгийн төсөвт өртөгөөр барьж ашиглалтанд оруулсан.



Орон нутгийн хөгжлийн



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийдэд нийтийн бие засах газар 60 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулсан.



Орон нутгийн хөгжлийн сангийн



хөрөнгө оруулалтаар Орхон суманд нийтийн халуун усны барилгыг 80,5 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хушаат сум Орхон гол дээгүүр 235 метр төмөр бетон гүүр 3,75 тэрбум төгрөгөөр баригдаж ашиглалтанд орсон нь манай Аймгийн ургац тээвэрлэлт болон ачаа, нийтийн зорчигч тээвэрт стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалт болсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна засвар шинэчлэлт ажил 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдсэн. Мөн Аймгийн оношлогооны төвийг байгуулахад зориулж байрны засвар, тохижилтын ажилд нийт 180 сая төгрөг батлагдаж ажил хийгдэж байна.



Цагааннуур сумын
цэцэрлэгийн засварын ажлыг
Орон нутгийн хөгжлийн
сангийн 140 сая төгрөгийн
хөрөнгө оруулалтаар хийж
гүйцэтгэсэн.



Ерөө сумын цэцэрлэгийн цэвэр бохир усны сангийн засварын ажлыг Орон
нутгийн хөгжлийн сангаас 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.



Ерөө суманд Орон нутгийн хөгжлийн сангаас 34 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ногоо хадгалах зоорийн барилга баригдаж дууссан



Жавхлант суманд 25 сая төгрөгөөр баруун хороололд гаргасан гүний худаг



Хушаат сумын цэцэрлэгт хүрээлэнгийн худаг



Хушаат суманд хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 42 сая төгрөгөөр хэрэгцээтэй газруудад худаг гаргасан.

Орхон суманд хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 30 сая төгрөгөөр бэлчээрийн гүний худаг гаргасан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Шаамар суманд 80 сая, Зүүнбүрэн суманд 55 сая төгрөгөөр тус тус наадмын талбай баригдаад байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёмбо цогцолборын замын барилгыг 300 сая төгрөгийн төсөвт өртгөөр барьж ашиглалтанд оруулсан.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг сумын “Хаалга цогцолбор”-ыг 14 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар суманд 0,8км дулааны шугам шинэчлэх ажлыг 638 сая төгрөгөөр, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1км дулааны шугам шинэчлэлийн ажлыг 750 сая төгрөгөөр хийгдээд байна.



Сайхан сум Хөтөл хот, Номгон тосгоны инженерийн шугам засварын ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 240 сая төгрөг батлагдаж ашиглалтанд орсон.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сант суманд 100 сая төгрөгөөр сумын төвийн цэвэр усны шугамын шинчэлэл хийх усан санг засварлах ажлыг бүрэн дууссан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн суманд инженерийн шугам сүлжээний засвар шиэчлэлийн ажил нийт 80 сая төгрөгийн хийгдээд байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жавхлант суманд 3 тэрбум төгрөгийн төсвөөр 7 км хатуу хучилттай зам тавьж Улсын комиссд хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Алтан булаг суманд 0,5 км урт 140 сая төгрөгийн төсөвтэй хатуу хучилттай авт зам тавьж ашиглалтанд оруулаад байна.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын 42-р зөрлөгийн хайргаган хучилттай авто замын засвар шинэчлэлийн ажлыг 56 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 330,75 сая төгрөгөөр 17 суманд зам засвар, гэрэлтүүлэг замын тэмдэг тавих ажил хийгдсэн.





Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Худэр суманд 84 сая төгрөгөөр хайрган хучилттай авто зам тавьсан.

Мөн түшиг суманд 80 сая төгрөгөөр хайрган хучилттай авто зам тавьсан.

Жавхлант сумын 2-р багт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20 сая төгрөгөөр 0,4 кВ-ын цахилгааны дэд станц барьж ашиглалтанд оруулж айл өрхүүдийг эрчим хүчээр хангаад байна.

Мөн Хушаат сумын Дуулга хороололд цахилгааны шугам барих ажил 30 сая төгрөг.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын Хэрх тосгонд 35/6 кВ-ын цахилгааны дэд станцын ажил 463,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдлээ.



Аймгийн төсвийн 169 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар суманд хамгаалалтын камер тавьж ашиглалтанд оруулсан.

